

“Монголын Намар-Айрагны Баяр 2011”

Ажил, амьдрал өрнөсөн алтан намрын өдрүүд айлчлан иржээ.

Ирэх 2012 онд Монгол-Япон хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ой болно. Энэ хугацааны туршид хоёр орны олон талт хамтын ажиллагаа өргөжин бэхжихийн зэрэгцээ эдийн засаг, нийгэм, боловсрол, соёл, шинжлэх ухааны гээд бүхий л салбарт тоочоод барамгүй олон сайхан хамтарсан үйл явдал арвин байж, тухайн гүрнүүдийн түүхийн хуудсыг нэжгээдээр зузаалсаныг дурьдахад таатай байна. Энэхүү түүхэн тэмдэглэлт ойг угтал болгохын сацуу японд болсон байгалын гамшигт нэрвэгдсэн анд нөхөддөө өчүүхэн төдий ч болов сэтгэлийн дэм өгөх зорилгоор “Монголын Намар-Айрагны Баяр 2011”-ыг анх удаагаа Тоокёо хотноо зохион байгуулах гэж байна.

Хугацаа: 2011 оны 10 сарын 22-ны өдөр (Бямба) 10:00 - 17:00 цагт

Байр: Тайто дүүргийн Шоогай Гакүшюү төв, Кокуруицү Кинрюү цэцэрлэг
(台東区生涯学習センター・区立金竜公園、台東区西浅草 3-25-16)

Байршлын газрын зураг:



Ойролцоох өртөө : Цүкүба экспресс шугам Асакуса буудлаас 5 минут
Метроны Хибияя шугам Ирияа буудлаас 8 минут
JR Яманотэ шугам Үгүйсудани буудлаас 15 минут

Холбоо барих : Хүрэлтогоо 080-3448-6209, Заяа 080-5097-5163, Зориг 080-4452-1172,

Зохиогдох арга хэмжээ : Монгол сумочид маань баяраа дэмжин ирж оролцохын зэрэгцээ,

- Үндэсний хөгжмийн цөөхүүлийн тоглолт
- Монгол болон бусад төрлийн хоолны худалдаа
- Японы үйлдвэрийн айраг болон Асахи шар айрагны худалдаа
- Монголын нийгэм, урлаг соёлыг танилцуулах зургийн үзэсгэлэн
- Хандивын зорилгоор массаж, мэргэний булан
- Монголын дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний дэлгүүр
- Монгол наадгай булан (шагай, дуу, бүжиг) ажиллана.

Зохион байгуулагч: /Монголчуудын холбоо – Япон (МАЖ), МҮХАҮТ-ын Япон дахь Салбар Танхим, Айраг клуб/ Дэмжигч : /Япон дахь Монгол Улсын Элчин Сайдын Яам, Тоокёо хотын Тайто дүүрэг, VIMO SNS , МОНЦАМЭ Сонины Газар/

*** Айрагны баяртаа монгол үндэсний хувцастайгаа ирж оролцохыг уриалж байна!**